

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(24-32)

Монгол хэлний дан үг шууд бус,
дам нэрлэлт бүхий болох тухай асуудалд

Г. Даваажаргал¹⁵

Хүний нийгмийн тогтвортой хөгжил, хүн төрөлхтөний танин мэдэхүй, амьдралын олон талт үзэгдэл, үйл ажиллагаанаас шалтгаалан шинэ нэр гарч ирдэг нь хэлэнд чухал үүрэгтэй. Хөдөлмөр бүтээлийн үр дүнд шинээр бий болсон юмс, шинээр таньж мэдсэн зүйлийг хэлнийхээ зүй тогтолд нийцүүлэн нэрлэх шаардлага урган гарсаар байдаг. Тэгэхдээ бодит байдал, бодит ертөнцийн юм үзэгдлийн хязгааргүй олон талыг нээгээд хэлний хязгаарлагдмал хэрэглүүрүүдийг ашиглах хэрэгтэй болно. Аливааг нэрлэх нь ертөнцийн юм үзэгдлийн мөн чанарыг танин мэдэхэд чиглэсэн хүний сэтгэхүйн үйл ажиллагааны үр дүн болдог юм.

Хэлний бус мэдээлэл нь хэлний тэмдгээр илрэхдээ уг цаад юмны “хуулга” байдлаар илрэх ба өөрөөр хэлбэл хэлний тэмдгийн хэлбэрт нь уг цаад юмны агуулга биежиж илэрдэг аж. Иймээс үгийн утга бол тухайн үгийн авианы бүрхэвчинд биежсэн ухагдахуун яаж хувьсаж, хөгжиж байгааг харуулах тойрог замд татагдан орж байдаг юм. Жишээлбэл: бараа бүтээгдэхүүн ховор зэвэр нийгмийн нэгэн цаг үед ШАГ буюу “шил архи гарга” гэдгийг товчилсон хэлбэр нэлээд идэвхтэй хэрэглэгдэж улмаар, “шаглах” буюу *бөөний үнээр архи авч илүү үнээр зарах* гэсэн утга бүхий үйл үг үүссэн. Харин үнийг чөлөөлж, архи зэрэг барааг авах, хэрэглэхэд хорио цээр байхгүй болсон өнөө үед тэр үгийг хэрэглэх шаардлагагүй болжээ. Өөрөөр хэлбэл ШАГ гэх үйл байхгүй болсон учир тухайн үг хэрэглээнээс гарах шинжтэй болсон байна.

Тэгвэл, халуун гэсэн тэмдэг нэрэнд үйл үг бүтээх –р дагавар залгаж үүссэн “халуурах” гэдэг үгийн үндсэн утга нь *өвчний улмаас биеийн халуун нэмэгдэх* юм. Гэтэл ярианы хэлэнд энэхүү үг:

- Ярианд халуурах: ярих байсан зүйлээсээ хэтэрч, их зүйл ярих
- Архинд халуурах: архийг их хэмжээгээр уух

гэсэн шууд бус нэрлэлтийн утгаар хэрэглэгдэж байгаа нь “халуун” гэх шинж заасан үгийн юмны *эрчим нэмэгдэх, дээшлэх, ихсэх, хэвийн биш болох* гэх утгыг онцлон, шилжүүлсэнтэй холбоотой байна.

Ийнхүү ШАГ гэх үгийн тэмдэглэх ухагдахуун байхгүй болсонтой холбоотойгоор түүний хэрэглээ багасч байгаа бол, халуурах гэх үгийн тэмдэглэх ухагдахууны агуулга нэмэгдэж шууд ба шууд бус нэрлэлтийн утгаар хэрэглэгдэж байна.

Хүн хэлний нэрлэлтийн шинэ нэгжийг бий болгохдоо тухайн хэлэнд бэлэн байгаа ямар нэг материал хэрэглэгдэхүүнийг авч ашиглах бөгөөд өөрөөр хэлбэл, шинэ ухагдахуун, ойлголт юм уу, тэдгээрийн хоорондох шинэ харьцаа болгоныг тэмдэглэхийн тулд тухайн хэлний авиалбарыг цоо шинээр холбох, эсвэл хэлний үгийн санд ер байхгүй үг, холбоо үгийг тэр болгон шинээр бий болгодоггүй бөгөөд хэлэнд байсан тэмдгийг шинэ нэрлэлтийн үүргээр ашигладаг. Ер нь орчин цагийн хэлэнд үгийн гаралзүйг

¹⁵“Гурван-Эрдэнэ” БДС-ийн багш (Ph.D)

тодорхойлох аргаар утгын хувирлыг нь тодорхойлж болохуйц шинээр зохиосон нэрлэлт маш цөөхөн. Жишээ нь, Д. И. Менделеев химийн нэг элемент байна гэдгийг утгаж хэлээд тэр элементээ экасицилий гэж нэрлэе гэсэн байдаг. Үүнийг сүүлд лавсан гэх болсон. Ийм мэтчилэн шинээр зохиосон зүйл хуруу дарам цөөхөн. Тэгэхлээр ихэнх нэрлэлт бол өөр юмын нэрийг хэрэглэж үүссэн байна. Хэлний шинэ тэмдгийг тухай бүр зохиогоод байх юм бол уг хэлээрээ харилцаж чадахгүйд хүрнэ. Иймээс юмыг шинээр нэрлэнэ гэдэг бол шинэ бий болж байгаа буюу тархинд үүсч байгаа дүрийг хэлний нэгжийн утга болсон адил төстэй дүрд хуулан буулгаж байгаа зүйл юм гэж ойлгох хэрэгтэй. Хэлний бэлэн утгыг шинэ дүрд наах хавсаргах гэдэг нь хэл өөрийн үүргээ гүйцэтгэж байгаа бодит үйл явц бөгөөд үгийн утга, өгүүлбэрийн байгууламж нь хэлж ярьж буй уг зүйлд дасан зохицож, түүнд нэвчин шингэж байна гэсэн үг. Ингэснээрээ тухайн утгыг хийсвэрлэн ойлгох боломжийг ямагт бүрдүүлж байдаг. Жишээ нь: “ажил чөдөрлөх” гэж хэлэлцдэг нь *ажлыг морь шиг явж байдаг зүйл* гэж монгол хүн ойлгодогтой холбоотой. Үйл явц нь бүтэмжтэй байсан ажил зогсохыг морины хөлийг чөдөрлөхөд, явдал нь хязгаарлагддаг байдалтай адил гэж хийсвэрлэн төсөөлсний улмаас дээрх хэллэг үүсчээ. Ийнхүү, өөр зүйлд байсан бэлэн нэрлэлтийг авч тухайн зүйлээ нэрлэх нь хэл өөрийн үндсэн үүргээ гүйцэтгэж байгаа хэрэг юм. Хүний шинээр таньж мэдэж болох зүйлийг илэрхийлэх чадамжгүй байсан бол хэл, жинхэнэ ухамсрын зүйл байх боломжгүй. Хоорондоо төсөөгүй зүйлсийг, тэдгээрт байх аль нэг шинжийг онцлон, адилсуулан нэрлэх нь хэл бол ухамсрын зүйл юм гэдгийг харуулна.

Шинэ нэрлэлт хэлэнд бэлэн байсан зүйлээс үүсдэгийн хувьд урьдаас сайн таньж мэдсэн зүйлдээ тулгуурлах нь зайлшгүй. Шинэ ухагдахуун болгон нь бусад ухагдахуунтай ямар нэг байдлаар харьцаа холбоотой байх ба юмсыг таньж мэдэх гэдэг нь тэдгээрийн хоорондын харьцааны хэв маягийг таньж мэдэж болно гэсэн үг ажээ.

Хэлний илэрхийллийн тухайн нэг хэлбэр нь анх тэмдэглэж байснаасаа өөр юмыг тэмдэглэх, үгүй бол анхныхаасаа өөр үүрэгтэй болж болно. Түүнчлэн уул юм үзэгдэл, үйл байдал, шинж чанар нь нэгэн үе нэг нэртэй байснаа өөр нэг цаг үед өөр нэртэй болдог үзэгдэл түгээмэл байдаг. Энэ нь хэлний үзэгдэл баримт, ялангуяа юмыг хэлээр илэрхийлэх нэрлэх мөн чанар тэнцүү хэмнэл (симметрикт)-тэй биш харин тэнцвэргүй хэмнэл (ассиметрикт)-тэй байдагтай холбоотой юм. Үүнээс үүдээд нэг зүйлийн юмны нэрлэлт нь өөр нэг зүйлийн нэрлэлт болох, эсвэл өөр нэг зүйлийн үүрэгтэй болдог байна. Хэл шинжлэлд уг үзэгдлийг *анхдагч ба хоёрдогч нэрлэлт, шууд ба шууд бус* нэрлэлт гэх мэтээр томъёолсон байдаг.

Хоёрдогч нэрлэлт нь, ойлголтуудын бие биедээ шилжих чанарыг ашиглан, хуучин таньж мэдсэн зүйл дээрээ үндэслэн бодит байдлын шинэ шинж чанарыг тусгах маягаар үүсэн буй болдог. Үндсэндээ, нэг юмын нэрийг өөр нэг юманд шилжүүлж байгаа нь хоёрдогч нэрлэлт болох юм. Тухайлбал: “Цаадах чинь чоно шүү дээ” гэхэд чоно гэдэг амьтны нэр, хүнд шилжиж байгаа учраас хоёрдогч нэрлэлт болжээ. Гэхдээ хэлэнд байсан чоно гэдэг нэрийг зүгээр л сэргээн хэрэглэж байгаа гэдгээр хязгаарлаж болохгүй бөгөөд түүний “ширүүн, догшин” шинж чанарыг “хуулж” хүнд авчирч наасан утгатай болгож байна. Нүүдлийн мал аж ахуйт монгол хүний хувьд амьжиргааны эх үүсвэр болсон малынх нь гол дайсан чоно бөгөөд түүнээс мал сүргээ хамгаалах, тэмцэх явцдаа нарийн башир арга ухаан, зэрлэг догшин авир ааш зэргээс нь *чоно бол ширүүн догшин амьтан* гэж таньсан танилтынхаа үндсэн дээр хүний ерийн жирийн аашнаас этгээд гажууд, ширүүн дориун ааш гаргаж байгаа хүнийг түүнтэй адилсуулан нэрлэсэн хэрэг. Мөн, “Саарал морь хуйхалж байна даа.” гэхэд сонсогч болон хэлэгч этгээдэд *үс ноос шатаах* гэсэн утга

бодогдохгүй ба морь хурдлан давхихыг ярилцаж байгаа юм. Энд, *өвс, үс зэргийг галаар шарах, хайрахад хурдан түргэн байх* шинжийг онцолжээ. "хуйхлах" гэдэг үгийн утгын хувьд: *үс ноосыг галаар түлэх, шатаах* гэдэг нь анхдагч нэрлэлт болж, хурдан морь богино хугацаанд их эрч хүч гаргаж байгаа гэдэг нь хоёрдогч нэрлэлт болсон бөгөөд энэ хоёр "хурдан, түргэн" гэсэн шинжээрээ адилсана. "Аймгийн шүүхээс Дунгармаа гэдэг залуухан цагаан хүүхэн манай суманд ирж өөдөө сөөргөө явалтай зарим хүмүүсийг ёстой л хуйхалж гарлаа"¹⁶ гэсэн өгүүлбэр дэх "хуйхлах" гэсэн үг *үнэн байдлыг хурц ширүүнээр илчлэх* хэмээх утга илэрхийлсэн нь түүний *ширүүн галаар шатаах* гэсэн анхдагч утгын "ширүүн" шинжээс адилтган үүсчээ. Эдгээр нь хэлэнд байгаа бэлэн нэрлэлтийг цоо шинэ харьцаанд шинэ нэрлэлт болгож байгаа хоёрдогч нэрлэлтийн жишээ юм.

Хоёрдогч нэрлэлтийг үүсгэж буй үйл явдал нь хэлний код буюу тайлал тэмдгийн хэм тэнцүү бус шинжтэй чухал холбоотой гэдгийг дээр өгүүлсэн ба үүнийг, хэлний тэмдгийн агуулгын ба гаргалгын тал нь шууд хамаарал байхгүй гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, шинээр нэрлэж байгаа нэрлэлт нь цаад юмтайгаа авалцмал холбоогүй байна. Жишээ нь: Дулмаа бол хонь гэхэд Дулмаа гэдэг хүн "хонь" (гэрийн тэжээвэр сүүн тэжээлт, хивдэг адгуус) гэх цаад зүйлтэйгээ холбоогүй тул хэм тэнцүү бус шинжтэй юм. Харин, монгол хүнээс "хонь" гэх амьтныг номхон дөлгөөний жишиг хэмжүүр болгодгийн үндсэн дээр энэхүү нэрлэлт үүсчээ.

Үгийн сангийн хоёрдогч нэрлэлт гэдэг бол хэлэнд бэлэн байгаа нэрлэх хэрэгслүүдийг шинээр нэрлэх зорилгоор ашиглахыг хэлэх ба хэлэнд бэхжин батажсан хоёрдогч нэрлэлт нь тухайн хэлний нэрлэлтийн дутууг гүйцээдэг арга хэрэглүүр болдог ажээ¹⁷.

"Урьд нь хэлэндээ бэлэн байсан нэрлэх хэрэглүүрийг шинэ үүрэгтэй болгож хэрэглэхийг "хоёрдогч нэрлэлт" (вторичная номинация) гэнэ. Энэхүү хоёрдогч нэрлэлтийн хүрээнд шууд бус нэрлэлт (непрямая номинация), дам нэрлэлт (косвенная номинация) гэсэн хоёр нэрлэлтийг ялган хэлэлцэх нь зүйтэй." хэмээн В. Н. Телия тодорхойлсонтой бид санал нэгдэж байна.

Үүний шууд бус нэрлэлт гэдэг нь тухайн үгийн өмнө нь илэрхийлж байсан утгаар зууч болгож юм үзэгдлийг шууд бусаар тусгах арга юм. Ингэхлээр шинээр нэрлэн тэмдэглэж буй уг юм үзэгдлийн аль нэг шинж нь утга санааны шинэ агуулгад шилжин орсноор шинэ нэрлэлтийн утгыг ухаж ойлгох дотоод хэлбэр (внутренняя форма) нь болно.

Харин дам нэрлэлт гэдэг нь шинэ нэрлэлт үүсэхдээ өөр нэг нэрлэлтийн утга санааны агуулга буюу түүний шууд бус нөлөөллөөр бий болдог үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл дам нэрлэлтийг үүсгэж байгаа тэрхүү өөр нэг нэрлэлт нь бодит байдлыг нэрлэлтийн шинэ харьцаанд тусган тодорхойлох бөгөөд ингэснээрээ тухайн бодит байдлыг авч үзэх нарийвчлалыг тогтоон чиглүүлэх онцлогтой байна гэж В. Н. Телия үзжээ.

Монгол хэлний дан үгээр илрэх шууд бус нэрлэлт ба дам нэрлэлтийг дээрх аргазүйг баримтлан тодорхойлъя.

а) Дөрлөх, хазаарлах, ногтлох гэсэн үгсийн хоёрдогч нэрлэлт нь адилтгах аргаар бий болсон "шууд бус нэрлэлт" болно. Энэ нь "Тухайн үгийн "урьд нь зааж байсан утга"-ыг ашиглаж юм үзэгдэл, шинж чанарыг "шууд бусаар нэрлэх арга"-ыг шууд бус нэрлэлт хэмээн үзнэ" гэсэн санаанд дээрх жишээнүүд тохирно гэж үзэж байна.


¹⁶ Доржготов, 1991,85

¹⁷ Языковая номинация, 1977, 129

б) Илжиг, могой, хувалз гэх зэрэг үгс нь дам нэрлэлт болно. Ингэж үзэх нь “Шинэ нэрлэлт үүсэхдээ өөр нэг нэрлэлтийн утга санааны агуулга буюу түүний шууд бус нөлөөллөөр бий болохыг дам нэрлэлт гэнэ” хэмээх санаанд дээрх жишээнүүд тохирно гэж үзэж байна.

“а” хэсэгт, малын тоног хэрэгслийн нэрийн илэрхийлэх анхдагч утгаас адилтгаж шууд бус нэрлэлтийн утгатай болсон буюу тухайн хэрэгслүүдийг ашиглаж хэрэглэх үүргээс адилтган үүссэн нэрлэлт болно. Жишээ нь:

“Би бол шингэн сүүний ааруул шиг эр дээ. Тэгэхэд энэ гурван жилийн дотор лав гэгч дөрлүүлээд л халшраад байдаг болсон юм шүү дээ”¹⁸ гэсэн уран зохиолын жишээн дэх дөрлөх хэмээх үгийн анхдагч утга нь үхрийн хамарт дөр зүүх юм. Бүх болон шар үхэр бие том, чадал ихтэй, сургаагүй бол гараар амар баригддаггүй хэдий ч, хамарт нь дөр хийхэд хүний гарын аясаар хөтлөгдөн эдэлгээнд хялбар ордог байна. Тэгэхлээр, үхрийн хамарт дөр хийж өөрийн эрхээр байлгаж болдог шиг хичнээн хатуу чанга хүн (дээрх жишээнд, цөцгийг нь ялгаж авсан шингэн сүүний ааруул тослоггүй, хатуу байх шинжийг нь онцлон бусдын арга эвэнд төдийлөн ордоггүй хахир хатуу хүнийг адилтгажээ) байлаа ч арга чадлаар эрхэндээ оруулж болно гэсэн адилсал үүсчээ. Өөрөөр хэлбэл,



гэсэн зураглал харагдаж байна. Мөн “Тоодой: - Та нар тэгж л бай, эмэгтэй дарга ямар байдгийг мэднээ. Өөрөө мэдээгүй байхад чинь л ногтлоод авчихсан, хөтлөөд явж байх вий”¹⁹ гэсэн жишээнд *ногтлуулсан морь мал уналга эдэлгээнд ордог шиг, даргынхаа арга эвд орсон хүн ажлаа хийхээс өөр аргагүй болдог* гэсэн адилсал үүсчээ.

Тэгвэл “б” хэсэгт жишээлсэн үгс нь анхны утгаас адилтгасан биш, харин ёгтолж, егөөдөн үүссэн тул дан үгийн дам нэрлэлт болж байна. Эдгээр амьтны амиа тэжээх зүй ёсны зохилдолгоо нь хүнд таагүй сэтгэгдэл төрүүлж, сөрөг үнэлэмжийг илэрхийлж байгаатай холбоотойгоор тухайн үг дам нэрлэлт бүхий болжээ.

Адилсуулах үзэгдэл нэгдүгээрт, тухайн хэлэнд урьдаас нэгэнт уламжилж тогтсон үлгэр загварыг аль болохоор тогтвортой хэвээр хадгалах, түүнд бусад хэлбэрийг захируулах хандлага, хоёрдугаарт нэгэнт тухайн үлгэр загварт урьд нь холбогдолгүй, өөр хэв шинжтэй зүйлийг адилсуулах аргаар өөр үлгэр загварт оруулж байдаг байна. Энэ нь бидний өмнө тэмдэглэсэн шууд бус ба дам нэрлэлтийн үүсэх гол аргууд юм.

Зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, задлаг хам бүтэц, дан үг зэрэг хэлний янз бүрийн нэгжүүд шууд бус, дам нэрлэлт бүхий болдог бөгөөд хэлц нэгжүүдийг судлахдаа прагматик, семантик, хэл соёлын баримт болох талаас нь авч үзвэл, эдгээрт сэтгэл хөдлөл (эмотивность), үнэлэмж (оценочность), яруу илэрхийлэх (экспрессивность) гэсэн гурван үндсэн шинж хамаарах юм. Эдгээр шинжийн тухай өгүүлье.

Эрдэмтэн Е. М. Вольф : “Үнэлэмжийн үндсэнд А г В гэсэн томъёо байх ба А-нь субъектийн үнэлэмжийг төлөөлж, В-нь түүний объект болж, харин г-нь “сайн/муу” гэх утгыг хадгалсан үнэлэмжийн харьцаа болно. Ингэхлээр үнэлэмжийн гол элементүүд нь субъект, объект болон үнэлэмжийн өгүүлэхүүн (предикат) болж байна. А г В гэсэн хэлбэр

¹⁸ Ванган, 1983,104

¹⁹ Ванган, 1983,93

дэх “г” өгүүлэхүүн нь үнэлэмжийн үндсийг тавьж, субъект, объектын хоорондын өвөрмөц үнэлэмжийн харьцааг тусгасан тэмдэг шинжээр тодорхойлогдоно. Эдгээр шинж тэмдгүүд нь –“сэтгэл хөдлөл”, “үнэлэмж” юм. Тодруулбал, “сэтгэл хөдлөл” (үнэлэмж) гэдэг нь А г В гэсэн бүтэц дэх г гэсэн үндсэн тэмдэг бөгөөд “сайн/муу” гэсэн хоёр утгатай байдаг. Сэтгэл хөдлөлийн шалтгаан бол субъектийн сэтгэлийн хөдлөлөөр объектод өгөх үнэлэмж юм. Би алиманд дуртай, харин Вася лийрэнд дуртай гэдэг жишээнд тухайн объектийн шинжийг тэмдэглээгүй бөгөөд харин түүнд хандах субъектийн харьцааг л гаргасан байна. Тэр миний нүдэнд дулаахан харагддаг. Тэр нүдэнд дулаахан хүн гэхэд нэгдүгээр өгүүлбэрт субъектээс объектод харьцах харьцааг онцолсон буюу өөрөөр хэлбэл сэтгэл хөдлөлийн үнэлэмжийг илэрхийлсэн бол, хоёрдугаар өгүүлбэрт объектийн өөрийнх нь шинж чанарыг өгүүлж ерийн үнэлэмжийг илэрхийлжээ”²⁰ гэсэн байна. Тэгэхлээр юуны өмнө сэтгэл хөдлөл гэдэг бол объектод шууд харьцахад гарч ирдэг бөгөөд ёсзүйн, гоозүйн гэх мэт үнэлэмжийн янз бүрийн хэлбэртэй байхын сацуу сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн нэгж нь яруу илэрхийлэх шинжтэй байдаг. Тодруулбал, үгийн утга дахь сэтгэл хөдлөлийн бүрэлдүүлбэр нь уран яруу байдлыг бий болгохтой нягт холбоотой байж, сонсогчийн сэтгэл хөдлөлийг төрүүлдэг²¹.

Монгол хэлний дан үгсээр ерийн болон сэтгэл хөдлөлийн үнэлэмж хэрхэн илрэхийг жишээлбэл, “айх” гэвэл ерийн үнэлэмж бүхий нэрлэлт болж, “навчийх, халчийх, хулалзах, шалчийх, навтгалзах, хулмаганах жижгэрэх” гэх зэрэг нь сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий нэрлэлт болох юм. Сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий тэдгээр үгс нь тухайн зүйлийн талаар өгүүлэгчийн хандлага, үнэлэмж ямар байгааг илүү нарийн тодорхой илэрхийлэх чадамжтай. “Хулалзах, хулмаганах” гэхэд гэм хийснээсээ болоод бусдаас айх, бэргэх гэсэн утгатай байгаа бол “навчийх, халчийх, шалчийх, жижгэрэх” гэх үгс нь, зориг мохох, хэн нэгний сүр хүчнээс айн сүрдэх гэсэн утгыг илэрхийлж байгаагаараа дээрх бүлэг үгээс ялгарч байна. Тэгэхээр эдгээр үг “айх” утгыг илэрхийлэх төдийгүй түүнийг хэрхэн үзэж, түүнд хэрхэн хандаж, үнэлж байгаагаа илэрхийлэх зорилготой байгаа учраас сэтгэл хөдлөлийн шинжтэй болжээ. Нэг үгээр хэлдэг зүйлийг ийнхүү олон үгээр хэлдэг нь тухайн зүйлийнхээ эрчийг ихэсгэж байгаа хэрэг бөгөөд энэ нь яруу илэрхийлэх шинж, сэтгэл хөдлөл, үнэлэмжтэй холбоотой юм.

Яруу илэрхийлэх шинж гэдгийг салангид үгийн тухайд биш, илэрхийллийн хүрээнд авч үзэх хэрэгтэй. Хэлэхүйн үзэгдэл болсон яруу илэрхийлэх шинж нь сэтгэл хөдлөл-сэдлийн үндсэн дээр гарч ирэх ба ярилцагчийн сэтгэл хөдлөлийн нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Энэхүү шинж бол харилцаанд оролцогч хүмүүсийн аль алинд нь хамаарах бөгөөд шууд бус, дам нэрлэлтийн амин чухал зүйл болно. Хэлний илэрхийлэл яруу илэрхийлэх шинжтэй байна гэдэг бол түүнд коннотаци буюу хамсмал утга²² байгаатай холбоотой. Хамсмал утгын үндсэн үүрэг нь хэл ярианы харилцах хэрэглээтэй холбоотой нөлөөллийн үүрэг юм. Тэрхүү нөлөөлөл нь ярьж хэлж байгаа бодит байдлын тухайн нөхцөлд чухал байх шинж чанарыг мэдээлэх замаар бий болно. Жишээ нь: Хорон муу санаатай хүнийг “могой” гэж хэлдэг. Могойн, нарийн биетэй, хөлгүй, хайрстай, зарим могой хорны булчирхайтай, хороо шахах зориулалт бүхий тусгай шүдтэй гэдэг шинжүүдээс зөвхөн *шүдээрээ хордуулдаг* гэдгийг онцолж, хүний хорон зан байдлыг илэрхийлэх хамсмал утга болгосон байна. Хортой могой ганц үсрэлтээр хазаж орхих бөгөөд энэ үед могойн хор дээд эрүүгээр нь дамжин шарх руу урсан орж хордуулдаг аж.

²⁰ Вольф, 1985, 37

²¹ Сандомирская, 114

²² Телия, 1986, 21

Хатгуулсан даруйдаа хорыг гадагшлуулахгүй бол тэр хэсэгтээ өвчлөх, хавдах, улмаар амь насанд ч аюул учирч болзошгүй гэнэ. Хэрэв бүх могой хортой байсан бол түүний, нарийн урт биетэй, мурилзаж явдаг зэрэг шинжүүд нь хүнд хор гай болдоггүй учраас ингэж дам нэрлэлт бүхий болохгүй байсан нь тодорхой. Ингээд уг хүний муу санаа, муухай үйлдэл нь могой шиг, тэр дундаа хор шиг нь байдаг гэдгийг онцлоод могой харсан хүн хатгуулахгүйн тулд дөлж зугтдаг шиг, хорон муу сэтгэлтэй хүнээс ямагт айж болгоомжлох хэрэгтэйг сануулж, муушаасан үнэлэмжийг илэрхийлснээрээ ёгтлолын аргаар утга шилжсэн “могой” гэдэг үг яруу илэрхийлэх шинжтэй болсон байна.

Зүйрлэх адилтгах байдлаар шууд бус, дам нэрлэлт үүсдэг ерөнхий зарчмын хувьд авч үзвэл үүсмэл бус ба үүсмэл үг (дагаврын аргаар бүтсэн үг) адилтгал зүйрлэлийн аргаар шууд бус, дам нэрлэлт үүсгэж байна. Дагаврын аргаар үг бүтэх нь хэлний хийсвэрлэл, оюун ухааны чадвар, хэлний хэмнэх зарчимтай холбоотой. Ийм аргаар бүтсэн үгийн үүсмэл утгыг тодорхойлохдоо тухайн язгуур, үндсээр илэрч байгаа утгаар баримжаа болгон мөшгөвөл ойлгомжтой.

Үүсмэл бус ба үүсмэл үгийн түвшинд ажиглахад үг бүрийн үндсэн утга шилжиж юм уу, эсвэл дагаврын аргаар үүссэн үг бүр шууд бус нэрлэлт, дам нэрлэлт бүхий болдоггүй байна. Үүний учрыг тайлбарлахын тулд эхлээд Телиягийн тайлбарласан дараах жишээг авч үзье. Тэрээр: Эрүүл мэнд, организм гэдэг үгсэд “төмөр” гэсэн үгийг холбоход “бат бэх, тогтвортой” гэсэн онцолмол шинж илэрч байна. “Железное воля/дисциплина/распорядок/режим” гэх зэргийн “хэлбэрэлтгүй, гуйвалтгүй, тууштай” гэсэн онцолмол утга нь “бат бөх” гэсэн шинж дээр тулгуурлан гарч ирнэ. Гэтэл “намерение, организованность” гэсэн үгс нь дээрх үгстэй утгын нэг айд хамаарагдах хэдий ч “железный” гэсэн үгтэй холбогддоггүй. Учир нь, намерение гэдэг нь ямар нэг зорилгодоо хүрэх бэлэн төлөвлөгөө биш учраас железно гэдэг үгтэй холбогдохгүй бөгөөд “воля” гэдгээс утгын ялгаатай байна. Организованность гэдэг нь хүний хатуу чанд дэглэм журамд оруулсан зан төлөв биш учраас энэ үгтэй мөн холбогдохгүй байна гэсэн нь тулгуур үг, түүний үгийн сан-утгазүйн онцлогоос хамаарч түүнд юм холбогдох, эс холбогдох нь хамаарах тухай өгүүлжээ. Үгийн сангийн шинэ утгын нэрлэх шинж, бодит байдлын “хэсгийг” төлөөлөх чадвар нь тулгуур нэрийн утгатай нягт холбоотой байдаг ажээ.

Монгол хэлний зүү, тэвнэ, шөвөг гэх нэгэн төрлийн багаж зэвсгийн нэрэнд үйл үг бүтээх дагавар залгахад тэвнэдэх – тэвнээр хөшиж, тэвхдэх; шөвөгдөх – шөвгөөр хатгах, цоолох гэсэн үг үүсч байгаа бол, зүү+дэ- гэсэн хэлбэр үүсэхгүй байгаа нь тухайн хэрэгслийн овор хэмжээтэй холбоотой. Зүү, тэвнэ, шөвгийн зүйлээр тухайн юмыг хатгаж, нүхлэх, цоолоход зүү овор хэмжээний хувьд бага болохоор төдий л үр дүнтэй биш байна. Тэгэхлээр зүүг ийм үйлд хэрэглэдэггүй учраас зүүдэ- гэх үйл үг үүсэхгүй байх нь мэдээж хэрэг юм. Өөрөөр хэлбэл, ингэж үүсэхгүй байгаа нь хэлний талаас тайлбарлагдахгүй (хэлний бүтцээс шалтгаалах зүйл биш гэсэн үг) бөгөөд хэлний бус хүчин зүйлтэй холбоотой. “Тэвнэдэх, шөвөгдөх” гэх хоёр үгийг шууд бус нэрлэлт бүхий болох эсэхээр нь харьцуулж үзвэл “үгээр шөвөгдөх, харцаар шөвөгдөх” гэх мэтээр “шөвөгдөх” гэдэг үгийн л утгыг хийсвэрлэж болж байна. Учир нь тэвнээр хатгах, шөвгөөр хатгах хоёр үйлийг харьцуулж, шөвгөөр хатгах нь илүү хурдан цоорох байдлаас үүдэн шууд бус нэрлэлт бүхий болжээ. Тэгэхлээр энд тэвнэ, зүү, шөвөг гэх багаж хэрэгсэл юмыг хатгах, цоолох үүргийн хувьд адил хэдий ч овор хэмжээ, гүйцэтгэх үүргийн байдлаараа шөвөг бол бусдаасаа “том” байх шинжийг нь онцолж улмаар шинэ нэрлэлтийн үүргээр хэрэглэсэн байна. Үг бүрээс шууд бус нэрлэлт үүсдэггүй нь

онцолсон утга, цаана нь байгаа шинжтэй холбоотой. Улмаар, “харцаар шөвөгдөх, үгээр шөвөгдөх” гэхэд байх суухын аргагүй болгох, байж ядуулах гэсэн утгатай ба энэ нь ерийн “харах, үг хэлэх”-ээс огт өөр, яруу илэрхийлэх үүрэгтэй байна. Шөвөгний үзүүр хурц байх шинжийг нь онцлон, “харц, үг” хоёр хурц байх нь шөвөгтэй адил юм гэж адилсуулаад, хэрэв шөвөгний хурц үзүүрээр хатгавал хүн огло харайн босдог шиг үгээр/харцаар “шөвөгдүүлсэн” хүн босч гүйдэггүй юм аа гэхэд байх, суух газраа олж яддаг гэсэн утгыг илэрхийлж, яруу илэрхийлэх шинжтэй болжээ. “Шөвөгдөх” гэх үг *хурц* гэсэн хамсмал утгатай болж, цаашлаад *хурц юм заримдаа хэцүү байдаг* гэж үнэлсэн үнэлэмжийн зүйл илэрч байна. Үнэндээ, юуг юутай авалцуулан холбож, адилсуулж үзэх нь хүний өөрийнх нь дурын хэрэг болохыг энэ мэтчилэн олон жишээнээс харж болно.

Тухайн үг шууд бус, дам нэрлэлт бүхий болно гэдэг нь харилцаа, адилсуулах холбоо, аналог буюу харьцуулал, үнэлэмж, сэтгэлийн хөдөлгөөн, яруу илэрхийлэх шинж гээд олон зүйлтэй холбоотой болохыг бид өмнө тэмдэглэсэн билээ. Үгсийн яруу илэрхийлэх ялгараа гэдэг бол шууд бус нэрлэлтийн үр дүн юм. Өөр нэгэн жишээ дурдъя: “Азаргал” гэх үйл үг *бусдыг хэтэрхий эзлэн ноёлох* гэсэн шууд бус утгаар хэрэглэгддэг. Тэгтэл бусад эцэг малын нэрээс “бухла-, буурла-, хуцла-, ухнал-” гэх үйл үг үүсээгүй хэрнээ “азаргал-” гэсэн үг үүсч улмаар шууд бус нэрлэлт бүхий болсон нь сонирхолтой. “Бух, буур, хуц, ухна, азарга”-д “эр, сүргийн манлай, эцэг мал” гэх утганцрууд нийтлэг холбогдоно. Гэтэл “азарга” бол “10-30 орчим тооны адууг хураадаг, өөрийн сүргээ хамгаалдаг” гэх зэрэг онцлог шинжээрээ бусад эцэг малаасаа ялгардаг. Тийм ч учраас азарга адуу гэх хэллэг, ойлголт байх хэрнээ “бух үхэр, буур тэмээ, хуц хонь, ухна ямаа” гэж огт байдаггүй. Учир нь тэдгээр эцэг малын сүргээ захирах шинж нь азарганыхаас өөр юм. Тэгвэл яагаад “бусдыг хүчээр эзлэн түрэмгийлэх” гэсэн санааг “азаргал-” гэдэг үгээр хэлж байгаа вэ гэсэн асуулт зүй ёсоор урган гарна. Хүн өөртөө хамгийн чухал хэрэгцээтэй юмаа нэрлэдэггүй хэрнээ хүний анхаарал татсан юмыг, өөрөөр хэлбэл гаж зүйлийг нэрлэдэг. Энэхүү үг нь, хүн хүнээс гажууд өөр авир гаргаж байгаа хүний аяг байдлыг хараад өмнө нь өөрийн сайн таньж мэдсэн зүйлтэй харьцуулж буюу эцэг малын дотроос азарга л сүргээ захирах чадвараараа ялгарч байгаа шинжийг нь онцлон шууд бус нэрлэлт бүхий болжээ. Азарга гүүгээ болон бусад адуугаа хураан, бөөгнүүлж байгаа байдал, бусдыг хүч чадлаараа дийлж эрхэндээ оруулж байгаа хүн хоёрыг харьцуулан жишиж “эрхэндээ оруулах” шинжээр нь авалцуулан холбож адилтган, нэрлэлт үүсгэсэн байна гэж хэлж болохоор байна. “Цаадах чинь бусдыг түрэмгийлж байна” гэх “цаадах чинь азаргалж байна” гэх хоёрыг харьцуулахад сүүлийн жишээ нь найруулгын эрчмээрээ, хүний сэтгэлийг хөдөлгөх шинж, яруу илэрхийлэх үүргээрээ илүү болох нь харагдана.

Шууд бус нэрлэлт бүхий дан үгийг хэрэглээгүйн үүднээс үзвэл, ижил зиндааны хүмүүсийн хооронд ярианы хэлэнд хэрэглэгдэх шинжтэй байна. Хүн өөрийн эрхэмлэх хүнтэй, эсвэл өөртэйгээ нас, боловсрол, зиндаа тэнцүү хүнтэй юм уу, өөрөөсөө доод эрэмбийн хүнтэй харьцаж байна уу гэдгээсээ шалтгаалаад юу ярьж хэлэх нь хамаардаг аж. Энэ нь хэлний хүчин зүйл биш, ерөөс хүний хүчин зүйлтэй холбоотой асуудал юм. Хэлэгч этгээд эхлээд өөрөө уг юманд хандаж дараа нь өөр хүнд уг хандлагаа илэрхийлнэ. Ижил орчин нөхцөлийг харилцааны хүрээнд бий болгоё гэдэг харилцааны санаархал нь сэтгэл хөдлөл, нөлөөлөх утгыг бий болгодог ажээ. Хэлэгч этгээд, энгийн жирийн хэлж болох зүйлийг шууд бусаар хэлж байгаа нь уг юмыг үнэлсэн үнэлэмж, харьцаа хандлагаа харилцаж буй нөгөө хүндээ илэрхийлж, түүнд нөлөөлж адилсуулан, түүний сэтгэл хөдлөлийн байдал ямар байгааг тандах зорилгыг агуулж байна. Жишээ нь:

Мэндээ – Хэрэв би, тав таван зуугаар нь тасалж хоёр газар хийгээгүй бол мөн балрав аа? Бүгдийг нь хуурайлуулчих нь байна шүү.

- Мөн муухай нөхөр өө.

- За дүүрч, өнгөрч²³ гэхэд хуурайл- хэмээх үг хулгай авах, хулгайд алдах гэсэн утга илэрхийлсэн. Харилцагч хоёр этгээдийн нэг нь мөнгөнийхөө хагасыг хулгайчид алдсанаа *Бүгдийг нь хулгайчид алдчих нь байна шүү* гэхийн оронд хуурайлуулах гэсэн шууд бус нэрлэлт бүхий дан үгийг сонгосон нь хэлж ярьж байгаа зүйлээ товч бөгөөд найруулгын эрчим ихтэйгээр сонсогч хүндээ хүргэх санааг агуулсны сацуу *ядахнаа нэг төгрөг ч үлдээгээгүй аваад явсан байна шүү* гэх мэдээллийг дамжуулсан нь сонсогчид тэр чигээрээ хүрч чадаж байна. Ингээд, мөнгөө алдсан болон тэр тухай сонссон хоёр хүнд мөнгөний хойноос харуусах сэтгэл адилхан төрж, түүнийг авсан хулгайчийн талаар: хүний үнэргүй, улаан цагаандаа гарсан этгээд юм даа хэмээх адил төсөөлөл, сэтгэгдэл бууж байна. Мөн:

Нөгөө Дууяа бий шүү дээ. Яагаав манай Бо-гийн авгай. Тэр чинь цаадахтай чинь зузаан гэнэ.

-Дууяагаар яриулъя. Гашуун нясуун юманд ч бас л хэд давдаг бөх гэсэн. Эхлээд Дууяагаар яриул. ²⁴ Гэсэн жишээн дэх нимгэн гэдгийн эсрэг утгатай зузаан гэх үгийн арвин их шинжийг нь онцлон зузаан нөхөрлөл, зузаан холбоо, зузаан танил гэх зэрэг шууд бус нэрлэлт үүсдэг. Дээрх жишээнд, жирийн нөхөрлөлөөс өөр, дотно, бие биедээ юугаар ч тусалж чадах хоёр хүний гүн харилцаа холбоог ашиглан өөрсдийн хэргээ бүтээх санаархлыг нэг нь нөгөөдөө дамжуулж байгаа ба, *Тэр чинь цаадахтай чинь зузаан гэнэ* гэхийг сонссон хүнд “Энэ ажил төвөггүй бүтэх юм байна” гэсэн бодол төрөх нь дамжиггүй. Ийнхүү энэ өгүүлбэрт зузаан гэсэн шууд бус нэрлэлт бүхий үгийг ашигласан нь хэлэгч, сонсогч, улмаар уншигч этгээдэд нэгэн ижил төсөөллийг төрүүлж, харилцааны ижил орчныг бий болгож байна.

Хэлний ямар ч нэгж шууд бус, дам нэрлэлт бүхий болох боломжтой. Ийм төрлийн нэгжүүд бүтцийн хувьд харилцан адилгүй байх хэдий ч сэтгэл хөдлөлийг илэрхийлэх шинж, үнэлэмж, яруу илэрхийлэх үүргээрээ адил байна. Түүнчлэн, хүн хэлний нэгжүүдийг шууд бус нэрлэлт бүхий болгохдоо өмнө таньсан бодит зүйлийнхээ аль нэг шинжийг, шинээр таньсан зүйл юмтайгаа харьцуулж, улмаар адилсуулан шинэ нэрлэлтийг үүсгэдэг ажээ. Шууд бус, дам нэрлэлт бүхий болсон нэгжийн утгыг тайлбарлахдаа бодитой зүйлтэй харьцуулж хийсвэр ухагдахууныг тодруулах нь оновчтой хэмээн бид үзэж байна.

SUMMARY

When human being produce new denotation of language, they use ready materials and newly connect the language phenomena to note new connections between new concept and understanding or reluctant to make new and unknown words which do not exist in the lexicology. But prefer to use existing signs to denote new things.

After human knows something, there is a need to create a sign to denote it. So denotation isn't only general denotation of events, manner of something but it's the denotation of attribute. It is known about what is the difference between attribution of old and new thing and

²³ Ванган, 1983, 169

²⁴ Барамсай, 1988, 40

comfortable to make choice. Whether is called in new and former denotation. The language expression could be different role from original one or mark new thing from originally marked one.

It is common to transfer former meaning into new meaning to call new concept in long time, which is connected to language equals symmetric but it's connected to language unequals (asymmetric). So one denotation transferred another one or role would be different, which was marked in linguistic as first and second denotation direct and indirect denotation. Second denotation could be created with the usage of meaning transfer from one into another and reflect new attribution of realities based on former known. Basically second denotation is transformation in the first meaning into another one. Any unit of language could be the first and second denotation. This kind of unit is differed in structure and same in role expressing emotion and values.

НОМЗҮЙ

1. Артюнова Н. Д. Языковая метафора. М. ,1979
2. Баянсан Ж. , Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. Уб. , 2002
3. Баянсан Ж. , Бодгаль үнэлэмжийн хамсмал утгыг яруу илэрхийлэхүйн шалтгаалцлал хэмээхийн учир. МУИС. МХСС. Эрдэм шинжилгээний бичиг Том XXXII(340) Уб. , 2010
4. Барамсай Ж. ,Эмд ордог өвс. Уб. ,1988
5. Ванган Л. , Жирийн хүмүүс Уб. ,1983
6. Вольф Е. М. Функциональная семантика оценки. М. ,1985
7. Вторичная номинация и ее виды. Языковая номинация, М. , 1977
8. Доржготов Ц. ,Түүвэр зохиол. Уб. ,1991
9. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Уб. ,2008
10. Сандомирская И. И. Эмотивный компонент в значении глагола. (статья)
11. Телия В. Н. Коннотативный аспект семантики номинативных единиц. М. ,1986
12. Цэвэл Я. , Монгол хэлний товч тайлбар толь. Уб. ,1966